

4. Ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох эрх

30. Ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгох эрхийн тухай зохицуулалт Монгол Улсын Үндсэн хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль зэрэг холбогдох эрх зүйн актуудад тусгалаа олон хэрэгжиж буй бөгөөд Монгол Улс хөдөлмөрлөх эрхийн тухай НҮБ-ын 7, Олон улсын хөдөлмөрийн байгууллага (цаашид "ОУХБ" гэх)-ын 20 гаруй конвенцид нэгдэн орсон болно.

31. Иргэн ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгох Монгол Улсын эрх зүйн орчин үндсэндээ бүрдэж байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулиудыг тус тус 2001 онд батлан хэрэгжүүлж байна. Эдгээр хуулиудын хүрээнд Монгол Улсын иргэдэд ажил, хөдөлмөр эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, гадаадын орнуудад хөдөлмөр эрхлэх нөхцөл, орчинг бүрдүүлэх асуудлуудыг шийдвэрлэсэн. 2010 онд багтаан тус хуулиудыг илүү боловсронгуй болгож, олон улсын нийтлэг хэм хэмжээнд тааруулан шинэчлэн батлуулахаар ажиллаж байна. 2009 оны байдлаар нийт 25.0 мянга орчим иргэдийг гадаадад хөдөлмөр эрхлүүлэхээр зуучилсан. Мөн онд 22568 ажилгүй иргэнийг мэргэжлийн сургалтад хамруулж, 2197472.3 мянган төгрөгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлсэн байна.

32. Танил тал харах, шан харамж өгч ажлын байраар хангагдах явдал Монгол Улсад байсаар байгаа хэдий ч хууль, эрх зүй болон хөдөлмөрийн зах зээлийн өрсөлдөөнтэй эдийн засгийн өөрчлөлтөд улам бүр шахагдаж, хэн боловсролтой, мэргэжилтэй, хэн практик дадлагатай, ажил хийх хүсэлтэй нь хүссэн ажилдаа орж ажиллах нөхцөл, орчин бүрдэж байна. Цаашид Монгол Улсын Засгийн газар иргэн хүн ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн харилцаанд тэгш эрхтэйгээр оролцох нөхцлийг бүрдүүлэх талаар шат дараатай олон арга хэмжээг авч ажиллаж байна.